



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 19

Номгон

Түгээмэл тархацтай ашигт малтмалын  
хайгуулын тусгай зөвшөөрөл олгох  
санал хэлэлцсэн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аж ахуйн нэгжүүдэд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоор ирүүлсэн саналыг хавсралтад зааснаар дэмжсүгэй.

2. Хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг олгож, олгосон тусгай зөвшөөрлүүдийн мэдээллийг мэргэжлийн байгууллагад хүргүүлж, кадастр, зураг зүйн системд бүртгүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 31-ний  
өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралт



ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ  
МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН САНАЛ

№	Сумын нэр	Аж ахуйн нэр (ХХК)	Талбайн нэр	Талбайн хэмжээ
1	2	3	4	5
1	Заг	Эх бүрдэн	Даваа цахир	57.15
2	Өлзийт	Гурван тахилгат оргил	Өвдөгийн худаг	25.34
3	Өлзийт	Харганат майнинг	Эмээлийн сайр	393.61
4	Баян-Овоо	Баян тойром	Суваг	399.79
5	Баян-Овоо	Оном очир	Цагаан толгой	399.2
6	Баян-Овоо	Ти Эй Ди Эй	Цагаан цахир	377.34
7	Баян-Овоо	Нью солайд майнинг	Шанд булаг	384.61
8	Бөмбөгөр	Биошим мандалт	Цагаан хавцгай	267.26
9	Бөмбөгөр	Хатан трэйвел	Дайргат	132.46
Нийт	Сум-4	Аж ахуйн нэгж-9	Талбай-9	Га-2436,76

\_\_\_\_\_ ооо